630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	21,961	21,433
630001	Төрийн өмчит ЕБС	21,687	21,158
630002	Хувийн ЕБС	274	275
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6,185	5,652
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	5,750	5,217
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	435	435
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,979	5,216
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	253	277
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3	3
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	2,469	2,480
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	134	137
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	212	235
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,599	1,688
650010	Гэрээт ажилтан	166	245
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	143	151

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,955,393,033.59	3,426,927,221.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,909,906,232.59	3,384,725,641.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,542,997,393.22	3,301,643,203.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,233,407.00	114,183,353.00
210101	Үндсэн цалин	33,716,523.00	112,298,354.00
210102	Нэмэгдэл	516,884.00	
210104	Урамшуулал	-	1,884,999.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,182,285.00	56,733,686.00
210201	Тэтгэврийн даатгал	5,382,285.00	56,733,686.00
210202	Тэтгэмжийн даатгал	200,000.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	160,000.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	40,000.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	400,000.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,210,764.00	5,450,824.00
210301	Гэрэл, цахилгаан	2,210,764.00	1,684,824.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	3,766,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	41,296,630.00	104,544,290.00
210401	Бичиг хэрэг	1,562,350.00	2,144,686.00
210402	Тээвэр, шатахуун	26,155,268.00	45,707,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,712.00	3,161,617.00
210404	Ном, хэвлэл	199,000.00	3,446,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	39,878,127.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,838,300.00	10,206,000.00
2105	Нормативт зардал	22,908,182.00	184,720,053.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,553,262.00	171,210,996.00
210502	Хоол, хүнс	2,354,920.00	4,623,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,885,407.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,260,730.00	58,738,856.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	42,234,562.00
210602	Тавилга	-	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	100,000.00
210604	Урсгал засвар	15,260,730.00	11,404,294.00
2107	Томилолт, зочны зардал	8,855,775.00	2,991,786.00
210702	Дотоод албан томилолт	8,855,775.00	2,991,786.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,422,087.83	8,091,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,661,837.00	8,026,499.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,760,250.83	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	5,179.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,363,627,532.39	2,766,188,677.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,297,619,632.39	2,739,318,820.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,007,900.00	26,869,857.00
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,136,000.00	5,760,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,136,000.00	5,760,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	550,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,800,000.00	4,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,786,000.00	1,760,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	336,772,839.37	77,322,437.80
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	8,505,121.00	
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	328,267,718.37	77,322,437.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,486,801.00	42,201,580.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,486,801.00	42,201,580.00
220001	Барилга байгууламж	-	

225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,486,801.00	42,201,580.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,488,243,529.60	3,396,347,653.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,488,243,529.60	3,396,347,653.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	385,492,566.36	307,357,925.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,552,499.00	41,803,815.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	856,793,780.83	2,850,092,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,404,683.41	197,093,563.80
131106	Төсвийн урамшуулал	-	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(467,149,503.99)	(30,579,567.99)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	510,103,197.30	42,953,693.31
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,953,693.31	12,374,125.32

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Д.Бауыржан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой зөвлөмжүүд менежментийн захидалд өгөгдсөн болно.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэж гаргаж ирүүлсэн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд **дунд** гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Засаг даргын дэргэд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Санхүүгийн хяналт, аудитын алба ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд нийт 99 нэгжид хяналт, шалгалт хийж, давхардсан тоогоор 184 нэгжийг хамруулжээ. Үүнээс төлөвлөгөөт 99, Сангийн сайдын удирдамжаар 2, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр болон иргэдийн өргөдөл гомдлоор 21 шалгалт хийж, дүгнэлт гаргасан байна.

Хяналт шалгалтаар нийтдээ 108.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 43.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг хангуулж, 64.7 сая төгрөгийн зөрчлийг төлүүлэх акт тогтоосон байна.

Актын дүнгээр орон нутгийн төсөвт 41.6 сая төгрөг оруулж, 23.1 сая төгрөгийг тухайн байгууллагад нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тайлант онд өмнөх онд төлөгдөөгүй актаас 4.0 сая төгрөг, тайлант оны актаас 30.0 сая төгрөг, бүгд 34.1 сая төгрөгийг төлбөр барагдуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумын төрийн сан, Санхүүгийн албаны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг дараах хэлбэрээр явуулж ирсэн байна. Үүнд:

1. Өдөр тутмын хяналт
2. Төлөвлөгөөт хяналт
3. Төлөвлөгөөт бус хяналт гэсэн хэлбэрээ явуулж ирсэн байна.

Өдөр тутмын хяналтаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан төрийн санд харьяалах төсөвт байгууллагуудын орлого, зарлагын хуулгыг өдөр бүр шалган буцсан гүйлгээ болон орлого бууруулах гүйлгээг хянаж, илэрсэн зөрчлийг холбогдох сумуудын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, төлбөр тооцооны мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч тухай бүр арилгуулан ажилласан байна.

Freebalance программаар хийгдсэн гүйлгээ, ЗГСУМС-д оролцож буй хэрэглэгчийн бүртгэл, 2020 онд шинээр томилогдсон нягтлан бодогчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшилцсөн эсэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шалгаж ажиллажээ. Төсөвт байгууллагуудад эрх олгосон нэмэлт санхүүжилт, улсын болон орон нутгийн төсвөөс олгосон урсгал санхүүжилт, тусгай зориулалтын шилжүүлгийг холбогдох хууль журмын дагуу хуваарилж зарцуулсан эсэхийг батлагдсан хуваарьтай тулган шалгаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэлийн программ, хэлбэлзлийн тайлантай тулган баталгаажуулж, хяналт хийж ажилласан байна.

Тайлант онд Ногооннуур, Буянт, Алтай, Цэнгэл, Улаанхус сум, Цагааннуур тосгонд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс Ковид-19 цар тахалтай холбоотой Ногооннуур сум, Цагааннуур тосгоноос бусад нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна. Харин Булган сумын Санхүүгийн албанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдэж шалгалтаар ямар нэгэн зөрчил гараагүй.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар:

- Ногооннуур сумын төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчиж , бүрдэл болоогүй баримтаар гүйлгээ хийсэн. Орлогыг сар бүр хугацаандаа хаадаггүй, зөрүүлдэг, мэдээ хожимдуулдаг, журнал ваучерыг зөрүүлдэг зэрэг зөрчил илэрчээ.
- Цагааннуур тосгоны санхүүгийн албаны үйл ажиллагаанд ямар нэгэн зөрчил гараагүй байна.

Өдөр тутмын хяналт шалгалтаар:

- Бугат, Улаанхус, Дэлүүн сумуудын санхүүгийн алба нь орлогыг сар бүр хугацаандаа хаадаггүй, зөрүүлдэг, мэдээ хожимдуулдаг, журнал ваучерыг зөрүүлдэг зэрэг алдаа дутагдал илэрсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 98792.7 сая төгрөгийн 1 хувь буюу 987.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны нийт зардал 112595.2 сая төгрөгийн 1 хувиар 1125.9 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд нийт зардлын 1 хувийг сонгосонтой холбоотой болно. Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлын түвшин төлөвлөлтийн шатанд тогтоосноос 138.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3455.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3195.0 сая төгрөг болж, оны эхнээс 260.0 сая төгрөгөөр буурсан байна.

<i>Хүснэгт №01 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	12.7	7.7	(5.0)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,442.3	3,187.3	(255.0)
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	3,455.0	3,195.0	(260.0)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	820.5	934.7	114.2
Төсөл/ сан	857.0	231.4	(625.6)
Төрийн сан	1,237.5	1,544.0	306.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	540.0	484.9	(55.1)
Дүн	3,455.0	3,195.0	(260.0)

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 12.7 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 3442.3 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна.

Оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 7.7 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 3187.3 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна.

Банкинд байршиж буй 3187.3 сая төгрөгт гадаад валютын мөнгөн хөрөнгө байхгүй байна. Банкинд байгаа 3187.3 сая төгрөгийн 2654.5 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл, 532.8 сая төгрөг нь арилжааны банкны үлдэгдэл байна. Үүнээс: 1166.1 сая төгрөг нь төсөвт байгууллага, төсөл сангийн, 1544.0 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 484.9 сая төгрөг нь ОНӨҮГ-ын дансны үлдэгдэлтэй байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл 2859.8 сая төгрөг байснаас 205.3 сая төгрөгөөр буурч оны эцэст 2654.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

<i>Хүснэгт №02 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг			
Нэмэлт санхүүжилт			
Банкинд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	2859.8	2654.5	205.3
Монгол банк			
Арилжааны банк			
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк			
Гадаад валют			
Монгол банк			
<i>Замд яваа хөрөнгө</i>			
Нийт дүн	2859.8	2654.5	205.3

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдэл 2859.8 сая төгрөгөөс тайлант онд 2047.6 сая төгрөгийг орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд, 530.1 сая төгрөгийг он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2654.5 сая төгрөгийг задалбал: 1533.7 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий дансны, 701.4 сая төгрөг нь ОНХС-ийн, 192.0 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 20.1 сая төгрөг нь Замын сангийн, 80.7 сая төгрөг нь Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, 61.4 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн мөнгө, 42.6 сая төгрөг нь сумдын БОХНСТС барьцаа дансны үлдэгдэл, 22.0 сая төгрөг нь Мал хамгаалах сан, 0.6 сая төгрөг нь бусад сангийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй байна. ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

Буянт сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь дансны хуулгаар 3748.9 мянган төгрөг, санхүүгийн тайланд 3778.9 төгрөгөөр буюу 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж ирүүлснийг залруулсан.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

3.5.3 Авлага

Авлагын оны эхний үлдэгдэл 5525.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6779.4 сая төгрөг болж, оны эхнээс 1253.9 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагыг дансны төрлөөр авч үзвэл: Төсөвт байгууллагын авлага 118.3 сая төгрөгөөр буурч, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн авлага 890.8 сая төгрөгөөр, төсөл сангийн авлага 481.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Төрийн сангийн авлагын дүнд өөрчлөлт ороогүй, барагдаагүй байна.

Хүснэгт №03	Авлагын үлдэгдэл		/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	205.7	265.8	60.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	134.0	92.7	-41.3
Татаас, санхүүжилтийн авлага	291.8	7.0	-284.8
Зээлийн хүүгийн авлага	10.9	9.6	1.3
Дансны авлага /ТӨҮГ/	6.5	6.5	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.1	0.1	-
Бусад авлага	1,061.6	1990.1	928.5
Зээлийн авлага	3,814.9	4407.6	592.7
Дүн	5,525.5	6,779.4	1253.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,988.1	2869.8	-118.3
Төсөл/ сан	1,219.7	1701.1	481.4
Төрийн сан	256.8	256.8	-
ОНӨҮГ	1,060.9	1951.7	890.8
Дүн	5,525.5	6,779.4	1253.9

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын өсөлтийг нийт дүнгээр нь авч үзвэл: аймгийн ТЕЗ-д шууд нэгтгэгддэг төсөвт байгууллага, төсөл сан, ОНӨҮГ-уудын авлага нийт дүнгээр 581.2 сая төгрөгөөр, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Цэнгэл, Өлгий сумын төсөвт байгууллага, төсөл сангуудын нийт авлага 2.4-378.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал:

Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Цэнгэл, Өлгий сум, Цагааннуур тосгоны Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 0.2-65.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогоос нэмж олгосон зээлийн дүнгээр нэмэгджээ.

Харин Булган, Улаанхус сумын Сум хөгжүүлэх сангийн авлага 27.1-55.8 сая төгрөгөөр буурсан нь авлагын эхний үлдэгдлээс барагдуулж, шинээр зээл олгогдоогүй байгаатай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 сарын 14-ны өдрийн А/990 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсөвт багц дотор зохицуулалт хийж хуваарилахдаа зарим байгууллагуудын төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлж олгосон нь оны эцэст нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн татвар болон бусад тооцоонд төсвийн хөрөнгийг тооцооноос илүү шилжүүлж шинээр авлага үүсгэхэд нөлөөлсөн байна.

Тайлант онд урьд байсан авлага дээр нэмж эсвэл шинээр авлага үүсгэсэн төсөвт байгууллагуудыг дурдвал: Алтай сумын Ерөнхий боловсролын сургууль 4.4 сая төгрөгөөр, Алтанцөгц сумын Хүүхдийн цэцэрлэг 46.8 сая төгрөгөөр, Эргэлтийн эмийн сан 3.4 сая

төгрөгөөр, Баяннуур сумын ЕБ-ын 3 дугаар сургууль, Эрүүл мэндийн төв, ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг 0.9-6.9 сая төгрөгөөр, Бугат сумын ЕБ-ын сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг 0.2-1.2 сая төгрөгөөр, Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг, ЕБ-ын 2 дугаар сургууль, ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв 0.2-5.2 сая төгрөгөөр, Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 7.0 сая төгрөгөөр, Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг Ерөнхий боловсролын 1, 2-р сургууль, ЗДТГ 0.2-3.3 сая төгрөгөөр, Ногооннуур сумын ИТХ, Ерөнхий боловсролын 4-р сургууль 0.1-3.8 сая төгрөгөөр, Сагсай сумын 2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төв 2.4-8.4 сая төгрөгөөр, Цэнгэл сумын ЗДТГ, 1, 2, 4 дүгээр цэцэрлэг, Ерөнхий боловсролын 3, 3-р сургууль 0.1-5.8 сая төгрөгөөр, Өлгий сумын ЗДТГ, ИТХ, Хот тохижуулах алба, хүүхдийн 1, 3, 6, 7, 8, 12, 13, 15, 16, 17, 19 дүгээр цэцэрлэгүүд, Хотгор цэцэрлэг, Ерөнхий боловсролын 1, 3, 4, 10 дугаар сургууль, Хотгор Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд 0.2-58.5 сая төгрөгөөр, Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв 0.05-3.4 сая төгрөгөөр авлага тус тус нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэлд шууд нэгтгэгддэг байгууллагуудаас Насан туршийн боловсролын төв, Орон нутгийн өмчийн газар, Спорт соёл, аялал жуулчлалын газар, Хөгжимт драмын театр, Асрамжийн газрын авлага 0.8-13.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон нутгийн өмчит “Суат” ХХК, Цахилгаан шугам сүлжээний газрын авлага 10.8-886.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газрын авлагын үлдэгдэл 1778.5 сая төгрөг болж 886.1 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоол гарч айл өрхийн болон дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүчийн төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх болсонтой холбоотой ахуйн нэгж, айл өрхийн цахилгааны төлбөрөөс авах авлага өссөнөөс шалтгаалжээ.

Цахилгаан шугам сүлжээний газрын авлагад 2009-2010 онуудад үүссэн олон жил болсон байгууллага, хувь хүмүүсээс авах барагдах боломжгүй 87.1 сая төгрөгийн авлага байгаагаас 45.6 сая төгрөгийн авлага нь шүүхийн тогтоол гарч найдваргүй авлагад бүртгэгдсэн байна.

Спорт соёл, аялал жуулчлалын газрын авлага дансны үлдэгдэл 13.1 сая төгрөг болж өссөн нь Биеийн тамир, спортын хорооноос “Цахим фитнес” төсөлд жилийн эцэст олгосон санхүүжилт төрийн санд татан төвлөрснөөс татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсөвт байгууллагуудаас тайлант оны төсвийн хэмнэлтийг жилийн эцэст төсөвт төвлөрүүлэхгүйгээр цалингийн татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бусад тооцоонд илүү шилжүүлж шинээр авлага үүсгэсэн зөрчил нийтлэг гарсан байна.

Тухайлбал: Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 3.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 0.5 сая төгрөгийн, Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 12.2 сая төгрөгийн, Бугат сумын Эрүүл мэндийн төв 7.2 сая төгрөгийн, Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 7.5 сая төгрөгийн, Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 5.2 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 1.5 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 5.2 сая төгрөгийн, Ёлт Хүүхдийн цэцэрлэг 3.9 сая төгрөгийн, Соёлын төв 0.2 сая төгрөгийн, Дэлүүн сумын сумын Засаг даргын тамгын газар 0.6 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 17.5 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 5.4 сая төгрөгийн, 3 дугаар сургууль 1.2 сая төгрөгийн, 2 дугаар цэцэрлэг 0.2 сая төгрөгийн,

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 8.4 сая төгрөгийн, Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 1.9 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 11.9 сая төгрөгийн, 3

дугаар сургууль 11.6 сая төгрөгийн, 1 дүгээр цэцэрлэг 0.6 сая төгрөгийн, 2 дугаар цэцэрлэг 1.5 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 5.7 сая төгрөгийн, Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 9.6 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 4-р сургууль 6.4 сая төгрөгийн, Толбо сумын ЗДТГ 2.0 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 4.3 сая төгрөгийн, Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 4.8 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2.8 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 4.9 сая төгрөгийн,

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль 52.2 сая төгрөгийн, 5 дугаар сургууль 2.2 сая төгрөгийн, 1 дүгээр сургууль 7.1 сая төгрөгийн, ЕБ-ын лаборатори 2 дугаар сургууль 7.3 сая төгрөгийн, 7 дугаар цэцэрлэг 1.3 сая төгрөгийн, 13 дугаар цэцэрлэг 3.9 сая төгрөгийн, 17 дугаар цэцэрлэг 2.9 сая төгрөгийн, 3 дугаар цэцэрлэг 1.7 сая төгрөгийн, 3 дугаар цэцэрлэг 1.7 сая төгрөгийн, 9 дүгээр цэцэрлэг 0.8 сая төгрөгийн, 18 дугаар цэцэрлэг 0.7 сая төгрөгийн, 19 дүгээр цэцэрлэг 0.6 сая төгрөгийн, 8 дугаар цэцэрлэг 0.9 сая төгрөгийн, Хотгор эмнэлэг 2.0 сая төгрөгийн, Асрамжийн газар 1.5 сая төгрөгийн, Насан туршийн боловсролын төв 0.2 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

- Зарим төсөвт байгууллага бусад тооцооны авлагаа нэмэгдүүлсэн байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль гэрэл цахилгаанд 0.2 сая төгрөгөөр, Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1, 3 дугаар сургууль нь хувь хүмүүс, ажилчдаас авах авлагыг 3.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, Бугат сумын Эрүүл мэндийн төв нь эмийн нийлүүлэгч байгууллагад 1.2 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль хоолны зардлаас бэлтгэн нийлүүлэгчид 2.0 сая төгрөгийн илүү шилжүүлсэн, Сагсай сумын Эрүүл мэндийн төв түлш халаалтын тооцоонд 2.3 сая төгрөгийг, Насан туршийн боловсролын төв ажилчидтай холбоотой 0.8 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

- Авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгах, харуулаагүй орхигдуулсан зөрчил зарим төсөвт байгууллагуудаас илэрсэн байна. Тухайлбал:

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар 0.2 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нийгмийн даатгалын шимтгэлийн 2.6 сая төгрөгийн, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 0.6 сая төгрөгийн, Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 4.6 сая төгрөгийн, Өлгий сумын ЕБ-ын 10 дугаар сургууль 3.1 сая төгрөгийн татварын авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг 0.1 сая төгрөгийн, Бугат сумын Засаг даргын тамгын газар 1.1 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургууль 1.5 сая төгрөгийн Эрүүл мэндийн төв 0.8 сая төгрөгийн, Сагсай сумын Засаг даргын тамгын газар 0.1 сая төгрөгийн, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 0.3 сая төгрөгийн, 2 дугаар цэцэрлэг 1.0 сая төгрөгийн, Өлгий сумын ЕБ-ын 9 дүгээр сургууль 0.1 сая төгрөгийн, 10 дугаар сургууль 0.5 сая төгрөгийн ажилтнуудад олгосон урьдчилгааг суутгаж аваагүй, авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулалгүй орхигдуулсан байна.

- Жилийн эцсийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил байна. Тухайлбал:

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2.2 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 3.9 сая төгрөгийн олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой авлагыг, Бугат сумын Засаг даргын тамгын газар ажилтнуудтай холбоотой он дамжсан 14.6 сая төгрөгийн авлагыг, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 0.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг, Өлгий сумын 17 дугаар цэцэрлэг оны эхний 1.2 сая төгрөгийн татварын авлагыг, Хөгжимт драмын театр 8.6 сая төгрөгийн түрээсийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

- Авлагатай холбоотой гарсан бусад зөрчлүүд:

Буянт сумын Сум хөгжүүлэх сан нь зээлийн авлагын үлдэгдлийг 43.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулсан.

Өлгий сумын Сум хөгжүүлэх сангийн зээлийн жагсаалтын үлдэгдэл санхүүгийн тайлангаас 5.2 сая төгрөгөөр зөрүүтэй, 22.4 сая төгрөгийн зээл нь программд ороогүй урьд тооцоогоор хаагдсан гэх боловч дахин тооцоо хийхэд үлдэгдэлтэй гарсан зээл байна.

Бугат сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангаар зээлийн авлагын эхний үлдэгдэл 197.4 сая төгрөг ба зээлийн авлагын жагсаалтаар 215.6 сая төгрөг, 18.1 сая төгрөгөөр зөрүүтэй. Эцсийн үлдэгдэл санхүүгийн тайланд 199.9 сая төгрөг ба жагсаалтаар 154.5 сая төгрөг, 45.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 13.4 сая, эцсийн үлдэгдэл 13.4 сая төгрөг болж, оны эхнээс 3.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №04 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13.4	13.4	0.0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
Дүн	13.4	13.4	0.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	13.4	13.4	0.0
Дүн	13.4	13.4	0.0

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд байгаа “Суат” ХХК-ны 2016 онд үүссэн 13.4 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь барагдаагүй байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант онд урьдчилгаа данстай холбоотой зөрчил гараагүй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын оны эхний үлдэгдэл 4533.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5140.7 сая төгрөг болж, оны эхнээс 606.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №05 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БАРАА МАТЕРИАЛ	4521.8	5128.6	606.9
Түүхий эд материал	271.1	311.5	40.4

Тусгай зориулалттай материал	148.2	133.1	-15.1
Эм боох материал	122.9	178.4	55.5
Бэлэн бүтээгдэхүүн	17.6	18.1	0.5
Хангамжийн материал	4037.9	4588.4	550.5
Бичиг хэргийн материал	77.0	86.7	9.7
Аж ахуйн материал	1923.3	2226.2	302.9
Сэлбэг хэрэгсэл	84.9	127.2	42.3
Түлш, шатах тослох материал	164.6	182.0	17.4
Барилгын засварын материал	9.8	11.4	1.6
Хүнсний материал	591.4	656.0	64.6
Бусад хангамжийн материал	1186.9	1298.8	111.9
Мал амьтад	195.2	210.7	15.5
Нөөцийн бараа	12.1	12.1	0
Дүн			
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4284.7	4850.5	565.8
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨҮГ	249.1	290.2	41.1
Дүн	4533.8	5140.7	606.9

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 94.3 хувийг буюу 4850.5 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын, 5.7 хувь буюу 290.2 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6439.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 407.0 сая төгрөгийн материал хүлээн авч, 5562.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 526.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Үүнээс төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 5616.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 407.1 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, 5296.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 160.7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд 823.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 266.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 516.7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Төсөвт байгууллагууд оны эцэст 100.2 сая төгрөгийн тусгай зориулалтын материалын, 131.8 сая төгрөгийн эм боох материалын, 18.1 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний, 85.6 сая төгрөгийн бичиг хэргийн материалын, 2156.1 сая төгрөгийн аж ахуйн материалын, 11.6 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн, 173.2 сая төгрөгийн түлш шатах тослох материалын, 11.4 сая төгрөгийн барилгын материалын, 649.8 сая төгрөгийн хүнсний материалын, 1289.8 сая төгрөгийн бусад хангамжийн материалын, 210.7 сая төгрөгийн мал амьтад, 12.1 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд оны эцэст 290.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй бөгөөд үүний 32.9 сая төгрөг нь тусгай зориулалтын, 46.5 сая төгрөг нь эм боох, 1.0 сая төгрөг нь бичиг хэргийн, 70.1 сая төгрөг нь аж ахуйн, 115.6 сая төгрөг нь сэлбэг хэрэгсэл, 8.7 сая төгрөг нь түлш, шатах тослох, 6.2 сая төгрөг нь хүнсний, 9.0 сая төгрөг нь бусад хангамжийн материал байна.

Зарим байгууллагууд бараа материалын үлдэгдлийг 0.5-302.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нийт бараа материалын үлдэгдлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл оны эхнээс 565.8 сая төгрөгөөр өссөн байна. Аж ахуйн материал 300.3 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 112.3 сая төгрөгөөр, хүнсний материал 62.9 сая төгрөгөөр, эм боох материал 44.4 сая төгрөгөөр, бусад бараа материал 0.5-15.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын материал өмнөх оноос 2.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалын бүртгэл, тооцоо, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Бараа материалыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан нийт 50.9 сая төгрөгийн зөрчил илэрчээ. Тухайлбал: Алтай сумын ЗДТГ 11.8 сая төгрөгийн, Бугат сумын ЭМТөв 15.8 сая төгрөгийн, Сагсай сумын хүүхдийн 1-р цэцэрлэг 5.0 сая төгрөгийн, Өрхийн Эрүүл мэндийн төв 12.1 сая төгрөгийн, Биеийн тамир, спортын газар 1.5 сая төгрөгийн, Асрамжийн газар 1.0 сая төгрөгийн, Ногооннуур сумын хүүхдийн 1-р цэцэрлэг 1.1 сая төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.
- Сургуулийн дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээ шаардлагаас илүү хэмжээгээр нөөцөлсний улмаас цар тахлын хязгаарлалттай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа зогсоход чанар байдлаа алдаж, хэрэглэх хугацаа дууссан нийт 47.5 сая төгрөгийн хүнсний зүйлийг Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн албан шаардлагын дагуу акталж данснаас хасаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил зарим, сургууль цэцэрлэгээс гарчээ. Тухайлбал: Алтай сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 12.4 сая төгрөгийн, 2-р сургууль 0.2 сая төгрөгийн, Алтанцөгц сумын Ерөнхий боловсролын сургууль 0.3 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 2.6 сая төгрөгийн, Булган сумын Хүүхдийн цэцэрлэг 5.2 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 2-р сургууль 1.7 сая төгрөгийн, 3-р сургууль 5.1 сая төгрөгийн, Толбо сумын Хүүхдийн цэцэрлэг 1.2 сая төгрөгийн, Ногооннуур сумын Хүүхдийн 1-р цэцэрлэг 1.4 сая төгрөгийн, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 12.7 сая төгрөгийн, 2-р сургууль 0.9 сая төгрөгийн, хүүхдийн 1-р цэцэрлэг 1.3 сая төгрөгийн, 2-р цэцэрлэг 2.4 сая төгрөгийн хүнсний материалыг тус тус акталж данснаас хассан байна.
- Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн акт дүгнэлтгүйгээр Буянт сумын сумын Ерөнхий боловсролын сургууль 4.7 сая төгрөгийн, Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 4.4 сая төгрөгийн, Дэлүүн сумын хүүхдийн 1-р цэцэрлэг 4.8 сая төгрөгийн чанар байдлаа алдаж, хэрэглэх хугацаа дууссан хүнсний материалыг акталж данснаас хассан зөрчил илэрсэн.
- Улаанхус сумын Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд дотуур байр болон цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг хэрэгцээнээс илүү нөөцөлж бараа материалын үлдэгдлийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн байна. Энэ нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж байгаатай, нөгөө талаар сумын төрийн сангаас нормативт зардлын төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, хяналт хангалтгүй хийгдсэнтэй холбоотой байна. Оны эцэст хүнсний материалын дансанд Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 61.7 сая төгрөгийн, 2 дугаар сургуульд 53.5 сая төгрөгийн, 3 дугаар сургуульд 61.5 сая төгрөгийн, Хөххөтөл цэцэрлэгт 15.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч хүнсний материалын их хэмжээний нөөц үүсгэсэн байна.

Тус сумын төвийн цэцэрлэг 35.2 сая төгрөгийн, Согогийн цэцэрлэг 33.6 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байгаагаар тайлагнасан боловч нярвын тайлбараар сумын төвийн цэцэрлэг 12.1 сая төгрөгийн, Согогийн цэцэрлэг 5.4 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байна. Энэ нь нярвын бараа материалын тайланг сар бүр гаргаж тооцоо хийгээгүй, хүнсний материалын үлдэгдлийн тооллого бодитой хийгдээгүй, тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаатай холбоотой байна.

Аудитын дүнгээр Улаанхус сумын Засаг даргад албан бичиг хүргүүлж дээрх хоёр цэцэрлэгийн хүнсний материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийлгэж, зөрчлийг арилгах чиглэл өгөв.

- Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хүнсний материалын үлдэгдлийг бодитой тоолж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, үлдэгдэл тооллогын бүртгэлээс 8.9 сая төгрөгөөр зөрүүтэй, үүний 5.7 сая төгрөг нь өмнөх няравтай холбоотой үлдэгдэл ба 3.2 сая төгрөгийн бараа материал дутагджээ. Аудитын явцад Булган сумын Засаг даргад албан бичиг хүргүүлж тус сургуулийн хүнсний материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийлгэж, үлдэгдлийг баталгаажуулсан бөгөөд нас барсан няравтай холбоотой хариуцах эзэнгүй үлдэгдлийг данснаас хасах чиглэл өгөв.
- Дэлүүн сумын ЕБ-ын 2-р сургууль дотуур байрны хүүхдийн хоол, хүнсэнд зориулан нөөцөлсөн 13.0 сая төгрөгийн махыг ажилтнуудад тарааж, биет байдлаар цуглуулж авсан боловч баримтжуулалт, тооцоо хяналт хангалтгүй хийгдсэн, Баяннуур сумын ЕБ-ын 2-р сургууль 4.4 сая төгрөгийн 810.2 кг махыг ажилчдад тарааж, үнийг цалингаас суутгаж авч ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд олгосон. Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг хоолны зардлын төсвөөс бараа материал худалдан авах, санхүүгийн программын лицензийн төлбөр зэрэгт 1.5 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүй зарцуулсан.
- Өлгий сумын Хүүхдийн 20 дугаар цэцэрлэг нь хүүхдийн хоолонд зарцуулсан материалыг тогоочийн бичсэн талон, няравын тайлантай тулгаж тооцоо хийхэд 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь нярав, тогооч, нягтлан бодогч нар ажлын уялдаа холбоогүй, нярав бараа материалын тайланг зохих журмын дагуу үнэн зөв гаргадаггүй, агуулахын бүртгэл хөтөлдөггүй байгаатай холбоотой байна.
- Дэлүүн сумын 3-р сургуулийн хүнсний материалын эхний үлдэгдэлд байсан 654 кг махыг дараа эргүүлж авахаар 14 иргэнд тараасан боловч жагсаалтад хүлээн авсан хүмүүсийн гарын үсгийг зуруулж баталгаажуулаагүй, захирлын ямар нэг зөвшөөрөлгүй байна.
- Ногооннуур сумын хүүхдийн 2-р цэцэрлэг Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Хүнсний дэмжлэг үзүүлэх тухай” А/162 дугаар тушаалын дагуу эрхлэгчийн тушаалаар зорилтод бүлгийн 60 хүүхдэд 5.7 сая төгрөгийн нөөцөлсөн хүнсийг олгохоор баталсан боловч 20 хүүхдэд олгосон 1.9 сая төгрөгийн хүнсний материалыг хүлээн авсан асран хамгаалагч нарын гарын үсэггүй, багийн засаг дарга нарын тодорхойлолтгүй, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн постын хоол хүнсэнд олгосон 1.0 сая төгрөгийн хүнсний зүйл хүлээн авсан хүмүүсийн гарын үсэггүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулжээ.
- Бараа материалын тооллогыг зохих журмаар хийгээгүй, үлдэгдлийг тооцоо бодож баталгаажуулаагүй, бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зэрэг нийт 566.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал: Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль 6.1 сая төгрөгийн, Баяннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 7.8 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 4.7 сая төгрөгийн, Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 8.9 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 8.8 сая төгрөгийн, Сагсай сумын ЭМТөв 50.0 сая төгрөгийн, Хүүхдийн 1-р цэцэрлэг 3.7 сая төгрөгийн, 2-р цэцэрлэг 2.3 сая төгрөгийн, Соёлын төв 3.4 сая төгрөгийн, Толбо сумын ЗДТГ 46.6 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургууль 4.4 сая төгрөгийн, Дэлүүн сумын ЕБ-ын 1-р сургууль 67.8 сая төгрөгийн, 3-р сургууль 37.7 сая төгрөгийн, Ногооннуур сумын Хүүхдийн 2-р цэцэрлэг 4.5 сая төгрөгийн, Улаанхус сумын ЕБ-ын 1-р сургууль 61.7 сая төгрөгийн, Хүүхдийн 1-р цэцэрлэг 35.1 сая төгрөгийн, Согог цэцэрлэг 82.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 3.2 сая төгрөгийн, Соёлын төв 9.8 сая төгрөгийн, Цагааннуур цэцэрлэг 12.4 сая төгрөгийн, Өлгий сумын 20 дугаар цэцэрлэг 2.5 сая төгрөгийн, ЕБ-ын 4 дүгээр сургууль 101.7 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.
- Нярав нь бараа материалын тайлан гаргадаггүй, зөвхөн нягтлан бодогчийн тайлангаар тооцоо хийдэг, агуулахын бүртгэл хөтлөөгүй, хөрөнгийн бүртгэл тооцоо хангалтгүй хийгдсэн зөрчил дараах байгууллагуудаас илэрчээ. Тухайлбал: Алтай

сумын Хүүхдийн цэцэрлэг, Баяннуур сумын Эрүүл мэндийн төв, Бугат сумын Эрүүл мэндийн төв, Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 3 дугаар сургууль, Улаанхус сумын хүүхдийн цэцэрлэгүүд, Өлгий сумын Засаг даргын тамгын газар, ЕБ-ын 4-р сургууль, Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг зэрэг байгууллагуудаас энэхүү зөрчил илэрсэн байна.

- Бугат сумын Эрүүл мэндийн төв 20.4 сая төгрөгийн тээвэр шатахууныг, Ногооннуур сумын хүүхдийн 2-р цэцэрлэг 8.4 сая төгрөгийн түлээ нүүрсийг зарцуулалтын анхан шатны баримтгүйгээр шууд зарцуулсан байна.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл нь нярвын тайлангийн үлдэгдлээс 37.5 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 40.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирлын тушаалаар нийт 20.1 сая төгрөгийн аж ахуй, хангамжийн материалыг акталж данснаас хассан байна. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дээрх хөрөнгийг акталж данснаас хасах талаар ямар нэг шийдвэр гаргуулаагүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 195397.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 214750.0 сая төгрөг болж, 19352.8 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №06 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл</i>		<i>/сая төгрөг/</i>	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	118736.3	132583.3	13847.0
Тээврийн хэрэгсэл	5096.2	5237.5	141.3
Машин тоног төхөөрөмж	28672.7	30156.5	1483.8
Тавилга эд хогшил	6234.6	6735.1	500.5
Зам гүүрийн байгууламж	7962.9	9545.0	1582.1
Түүх соёлын дурсгалт зүйл	1571.8	1584.8	13.0
Дуусаагүй барилга, байгууламж	2769.1	1371.1	-1398.0
Номын фонд	1542.8	1724.8	182.0
Бусад үндсэн хөрөнгө	12965.8	15891.4	2925.6
Програм хангамж	119.6	129.4	9.8
Бусад биет бус хөрөнгө	9725.4	9791.1	65.7
Дүн	195397.2	214750.0	19352.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	166746.5	185009.8	18263.3
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	28650.7	29740.2	1089.5
Дүн	195397.2	214750.0	19352.8

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн тайлангаарх нийт үндсэн хөрөнгийн 94.4 хувийг төсөвт байгууллагын, 5.6 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд нийт үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 558.6 сая төгрөгөөр, балансаас баланст шилжүүлэн авсан 3453.9 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хандиваар авсан 19624.3 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 20.5 сая төгрөгөөр, акталсан 685.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны оны эцсийн үлдэгдэлд 1371.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Бугат сумд 23.0 сая төгрөгийн, Дэлүүн сумд 529.0 сая төгрөгийн, Толбо сумд 0.1 сая төгрөгийн, Улаанхус сумд 404.0 сая төгрөгийн, Өлгий сумд 415.0 сая төгрөгийн дусаагүй барилга бүртгэлтэй байна.

Дээрх 1371.1 сая төгрөгийн дусаагүй барилга нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 2021 онд ашиглалтад орох барилга, байгууламж байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд нийтдээ 7810.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль жилийн эцсийн 428.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй, үнэ төлбөргүй олгосон номыг орлогод аваагүй, хөрөнгө оруулалтаар ирсэн тээврийн хэрэгслийг машин тоног төхөөрөмж дансанд орлого авч бүртгэсэн.
- Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тооллогын комисс 521.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын дансны үлдэгдлийг, Өлгий сумын хүүхдийн 20 дугаар цэцэрлэг 38.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг зохих журмаар тоолж баталгаажуулаагүй байна.
- Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнг хэлэлцсэн баримтгүй, тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
- Баяннуур сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Булган сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлд зарим хөрөнгийн нэг бүрийн үнэ, бүгд үнийг зөрүүтэй гаргаснаас тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байна.
- Ногооннуур сумын хүүхдийн 2-р цэцэрлэг жилийн эцэст 767.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолоогүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн программыг биет бус хөрөнгөөр бүртгэж орлого аваагүй байна.
- Цагааннуур тосгоны хүүхдийн цэцэрлэг жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, санхүүгийн тайланд тусгасан хөрөнгийн үлдэгдлийг хянаж баталгаажуулаагүй, Сагсай сумын Соёлын төв жилийн эцсийн тооллогын бүртгэлийг хангалтгүй хөтөлсөн байна.
- Улаанхус сумын Эрүүл мэндийн төв жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийхдээ барилга байгууламжийг 1.0 сая төгрөгөөр, тавилга эд хогшлыг 0.9 сая төгрөгөөр илүү, тоног төхөөрөмжийг 5.2 сая төгрөгөөр, биет бус хөрөнгийг 15.8 сая төгрөгөөр зөрүүтэй тоолж үлдэгдлийг баталгаажуулсан.
- Бугат сумын Эрүүл мэндийн төв төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2.8 сая төгрөгийн компьютер, принтер, хурууны хээ уншигч, камержуулалтын тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэж орлого аваагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлд зөвхөн хөрөнгийн тоо ширхгээр тусгасан тул санхүүгийн тайлан дахь хөрөнгийн дүнг тооллогын дүнтэй тулган баталгаажуулах боломжгүй байв.
- Толбо сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд олон жил он дамжсан 150.0 мянган төгрөгийн дуусаагүй барилгыг данснаас хасаагүй байна.
- Цахилгаан шугам сүлжээний газар тайлант онд зарим сумын багуудад трансформатор тавих, цахилгаан шугам татах зэрэг нийтдээ 12 төрлийн 351.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн боловч Орон нутгийн өмчийн

газраас орлого авах талаар холбогдох шийдвэр ирээгүй гэсэн нэрийдлээр орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан боловч хаалтын баланс гаргаагүй, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэлд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр шууд нэгтгэсэн байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 5223.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5775.6 сая төгрөг болж, оны эхнээс 551.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Тайлант онд богино хугацаат өр төлбөрөөс төсөвт байгууллагуудын өглөг 10.7 хувиар буурч, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өглөг 17.4 хувиар тус тус өсжээ. Урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл барагдаагүй байна.

Хүснэгт №07	Нийт өр төлбөрийн <u>үлдэгдэл</u>		<u>/сая төгрөг/</u>
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	1,938.1	2490.0	551.9
Өглөг	1,672.0	2223.9	551.9
Урьдчилж орсон орлого	266.1	266.1	-
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	3285.6	3285.6	-
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3127.6	3127.6	-
Хувь хүмүүсийн зээл	138.0	138.0	-
Санхүүгийн бусад байгууллага	20.0	20.0	-
<u>Нийт дүн</u>	<u>5,223.7</u>	<u>5775.6</u>	<u>551.9</u>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1272.6	1136.9	-135.7
Төсөл, сан	-		-
Төрийн сан	4.9	4.9	-
ОНӨҮГ	3,946.2	4633.8	687.6
ДҮН	<u>5,223.7</u>	<u>5775.6</u>	<u>551.9</u>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн 2490.0 сая төгрөгөөс урьдчилж орсон орлогыг хасахад богино хугацаат өглөгийн дүн 2223.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс: 1136.9 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын өр, 4.9 сая төгрөгийг төрийн сан, 1082.1 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өр эзэлж байна.

Тайлант онд нийт 61 төсөвт байгууллага 413.1 сая төгрөгөөр, 2 эмийн эргэлтийн эмийн сан 3.4 сая төгрөгөөр, 2 ОНХСан 29.6 сая төгрөгөөр, 2 ОНӨААН 703.1 сая төгрөгөөр өглөгийг нэмэгдүүлсэн бол 49 төсөвт байгууллага, ОНХСан, ОНӨААН нийт 305.4 сая төгрөгөөр өмнөх оны өглөгийг бууруулсан байна.

Оны эцэст 36 төсөвт байгууллага татварт нийт 108.1 сая төгрөгийн, 39 төсөвт байгууллага нийгмийн даатгалын шимтгэлд нийт 178.9 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК-ны өглөг 703.1 сая төгрөгөөр нэмэгдэж, “Хала өркени” ОНӨААТҮГ-ын өглөг 0.2 сая төгрөгөөр буурсан байна.

Төсөвт байгууллагуудын өглөг нэмэгдсэн шалтгааныг авч үзвэл:

- Орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын санхүүжилтийг дутуу олгосноос Улаанхус сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль 38.2 сая төгрөгөөр, 2-р сургууль 15.8 сая төгрөгөөр түлш халаалтын өглөг нь нэмэгдсэн байна.
- Зарим сургуулийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг өмнөх онуудад үндэслэлгүй бууруулж төлөвлөж олгосноос Өлгий сумын ЕБ-ын 1-р сургууль 28.9 сая төгрөгийн, 2-р сургууль 92.2 сая төгрөгийн, 3-р сургууль 18.9 сая төгрөгийн, 4-р сургууль 31.0 сая төгрөгийн, 6-р сургууль 7.3 сая төгрөгийн, Дэлүүн сумын ЕБ-ын 1-р сургууль 73.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
- Орон нутгийн төсвөөс олгох урсгал санхүүжилтийг дутуу олгосны улмаас Алтанцөгц сумын ЗДТГ 12.9 сая төгрөгийн, Баяннуур сумын ЗДТГ 11.8 сая төгрөгийн, Улаанхус сумын ЗДТГ 10.9 сая төгрөгийн, Бугат сумын ЗДТГ 8.4 сая төгрөгийн, Дэлүүн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 7.5 төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн байна.
- Булган сумын Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын хязгаарлалтын улмаас магадлан итгэмжлэл хугацаандаа хийгдээгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 21.2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авснаас 6.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
- Төсөвт байгууллагуудын оны эцэст хийгдсэн зарлагын зарим гүйлгээг төрийн сангийн сүлжээ гацсан, баталгаажуулах боломжгүй болсон, гүйлгээ буцаж ирсэн зэргээс шалтгаалан зарим байгууллага өглөгтэй гарсан байна.
Тухайлбал: Булган сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль 26.7 сая төгрөгийн, Буянт сумын ЕБ-ын сургууль 15.4 сая төгрөгийн, Ногооннуур сумын ЕБ-ын 1-р сургууль 12.4 сая төгрөгийн, Сагсай сумын ЕБ-ын 1-р сургууль 3.2 сая төгрөгийн, Баяннуур сумын Эрүүл мэндийн төв 6.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
Мөн Алтанцөгц сумын хүүхдийн цэцэрлэгийн оны эцсийн санхүүжилтээс 7.1 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлснээс 7.4 сая төгрөгийн, Биеийн тамир, спортын газарт Биеийн тамир, спортын хорооноос “Цахим фитнес” төсөлд олгосон санхүүжилт жилийн эцэст дансанд орж татан төвлөрснөөс 16.0 сая төгрөгийн, Хот тохижуулах алба мөн оны эцсийн санхүүжилтээс 14.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлснээс 14.2 сая төгрөгийн өглөг бүртгэсэн байна.
- Аймгийн Музейн халаалтын зардлын төсөвт дутуу суусан хэмжээгээр өр үүссэн тооцоог бэлтгэн нийлүүлэгч байгууллага нь шүүхэд өгч шүүхийн шийдвэрээр 15.4 сая төгрөгийн өглөгийг нэмж бүртгэсэн байна.
- Ногооннуур, Цагааннуур, Улаанхус сумын Соёлын төвүүдийн тус бүр 2 галчийн орон тооны цалинг төсөвт дутуу суулгасны улмаас он дамжсан 7.6-9.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
- Дэлүүн сумын Орон нутгийн хөгжлийн сан 20.8 сая төгрөгөөр, Сагсай сумын Орон нутгийн хөгжлийн сан 8.8 сая төгрөгөөр өглөгийг нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өглөг нэмэгдсэн нь:

- Цахилгаан шугам сүлжээний газрын өглөг Засгийн газрын айл өрхүүдээс хөнгөлсөн цахилгааны үнийг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д төлөхтэй холбоотой 580.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- “Суат” ХХК нь жил бүр алдагдалтай ажиллаж байгаагаас өглөг нь нэмэгдсэн байна.

“Жана өлке” ОНӨААТҮГ-т 266.1 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл бүртгэлтэй байгаа нь аймгийн ОНХСангаас 2014 онд олгосон 200.0 сая төгрөгийн зээл, иргэдээс урьдчилж авсан түрээсийн төлбөрийн 66.0 сая төгрөгийн өглөг байна.

Урт хугацаат өр төлбөр

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд нийтдээ 3127.6 сая төгрөгийн урт хугацаат өр бүртгэгдсэн байна.

“Суат” ХХК Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд аймгийн төвийн цэвэр бохир усны системийн техник, технологийг шинэчлэх цэвэр усны шугам хоолойг өргөтгөх, цэвэр бохир усны насосын станц, 30 хүний халуун усны барилгад их засвар, 3 ба 5 хүний халуун ус барих, ус түгээх, 2 ш гүний худаг барих, машин техник нийлүүлэх, цэвэрлэх байгууламжид био цөөрмийн карт барих зэрэг ажлуудад 2002 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 991.0 сая төгрөгийн зээлтэй байна.

Цахилгаан шугам сүлжээний газар Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Цахилгааны шугамын шинэчлэл, алдагдал бууруулах” төслөөр 2009 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 2136.6 сая төгрөгийн зээлтэй байна.

Дээрх төсөл хэрэгжсэн аж ахуйн нэгжүүдийн урт хугацаат хөрөнгө оруулалтын зээл нь санхүүгийн боломжгүйгээс төлөгдөөгүй ирсэн байна.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд Өлгий сумын Сум хөгжүүлэх сангаас авсан 20.0 сая төгрөгийн он дамжсан зээл барагдаагүй, “Жана өлке” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа иргэдээс павильоны анхны тавилтын үнийн урьдчилгаанд авсан 138.0 сая төгрөгийн хувь хүмүүсийн зээл бүртгэгдэж барагдаагүй байна.

Аудитын илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөртэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын өглөг оны эцэст 1136.9 сая төгрөгт болж оны эхнээс 156.1 сая төгрөгөөр өссөн байна.
- Зарим төсөвт байгууллагууд өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, өглөгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан, санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй зөрчил гаргасан байна. Тухайлбал: Өлгий сумын ЕБ-ын 4-р сургууль оны эхний 9.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулснаар тайлагнасан боловч баримтаар нотлох боломжгүй, тооцоо нийлсэн актгүй, жилийн эцсийн түлш халаалтын өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Ногооннуур сумын 1-р цэцэрлэг 0.9 сая төгрөгийн, Цэнгэл сумын 4-р цэцэрлэг 2.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Баяннуур сумын ЭМТөв 3.2 сая төгрөгийн, Бугат сумын ЭМТөв 5.5 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан,

Алтай сумын хүүхдийн цэцэрлэг Шүүхийн шийдвэрээр хоолны зардлын төсвөөс он дамжсан 1.9 сая төгрөгийн өглөгийг төлсөн боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй, Сум дундын ойн анги 0.1 сая төгрөгийн тогтмол зардлыг өглөгийн дансанд бүртгэж, тооцоо үүсгэхгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Алтай сумын хүүхдийн цэцэрлэг 0.4 сая төгрөгийн, Баяннуур сумын ЕБ-ын 3-р сургууль 0.1 сая төгрөгийн, Булган сумын ЗДТГ 0.4 сая төгрөгийн, Сагсай сумын ЭМТөв 1.0 сая төгрөгийн, Сагсай сумын ЕБ-ын 1-р сургууль 1.9 сая төгрөгийн, 2-р сургууль 2.4 сая төгрөгийн, Өлгий сумын ЗДТГ 0.5 сая төгрөгийн, Санхүүгийн хяналт аудитын алба 0.2 сая төгрөгийн, ГХБХБГ 0.3 сая төгрөгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй.

Ногооннуур сумын 2-р цэцэрлэг 2.6 сая төгрөгийн, Өлгий сумын 20-р цэцэрлэг 0.6 сая төгрөгийн, Орон нутгийн олон нийтийн радио телевиз 1.0 сая төгрөгийн, Музей 0.7 сая төгрөгийн, ГХБХБГ 0.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу ногдуулж санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй, Сагсай сумын ЭМТөв эмийн зардлын 1.3 сая төгрөгийн, Булган сумын Ёлт цэцэрлэг 0.2 сая төгрөгийн цалингийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй.

- Төсвийн тухай хуулийн 6.4-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зарим байгууллагын өглөг

нэмэгдсэн байна. Тухайлбал: Сагсай сумын 2-р цэцэрлэг 4.5 сая төгрөгийн, Соёлын төв 3.4 сая төгрөгийн, Ногооннуур сумын 1-р цэцэрлэг 4.3 сая төгрөгийн, ЕБ-ын 1-р сургууль 12.5 сая төгрөгийн, Улаанхус сумын ЭМТөв 9.6 сая төгрөгийн, Толбо сумын ЕБ-ын сургууль 1.3 сая төгрөгийн, Цэнгэл сумын ЕБ-ын 2-р сургууль 1.1 сая төгрөгийн, Насан туршийн боловсролын төв 0.9 сая төгрөгийн, Улаанхус сумын цэцэрлэг 14.8 сая төгрөгийн өглөгийг тус тус шинээр үүсгэсэн байна.

- Улаанхус сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль 61.7 сая төгрөгийн, 2-р сургууль 53.5 сая төгрөгийн, 3-р сургууль 61.5 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 35.2 сая төгрөгийн, Сагсай сумын ЕБ-ын 1-р сургууль 26.3 сая төгрөгийн хоол хүнс, түлээ нүүрсийг нөөцөлж худалдан авсан нь өглөг нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Энэ нь тухай байгууллагуудын төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнээс шалтгаалсан гэж үзэх үндэстэй байна.
- Батлагдсан орон тооны хязгаарыг Цагааннуур тосгоны Захирагчийн алба 5 хүнээр хэтрүүлэн 12.6 сая төгрөгийн, Бугат сумын Эрүүл мэндийн төв 7 хүнээр хэтрүүлж 11.3 сая төгрөгийн, Булган сумын Эрүүл мэндийн төв 2 хүнээр хэтрүүлж 6.6 сая төгрөгийн, Алтанцөгц Соёлын төв 2 хүнээр хэтрүүлж 9.5 сая төгрөгийн, Баяннуур сумын Соёлын төв 1 хүнээр хэтрүүлж 1.5 сая төгрөгийн, Бугат сумын Соёлын төв 2 хүнээр хэтрүүлж 4.3 сая төгрөгийн, Баяннуур сумын ЕБ-ын 3-р сургууль 1 хүнээр хэтрүүлэн 3.5 сая төгрөгийн өглөгийг тус тус шинээр үүсгэсэн байна.
- Ногооннуур сумын Соёлын төвийн төсвөөс нягтлан бодогч нь нягтлан бодогчийн цалинг тушаалд заасан хэмжээнээс хууль бусаар илүү авсан нь нийгмийн даатгалын шимтгэл, татварын өглөг 5.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 167233.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 180419.6 сая төгрөг болж, оны эхнээс 13186.2 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №08 Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл</i>		<i>/сая төгрөг/</i>	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	68,930.00	69,595.70	665.70
Өмч: -төрийн	68,930.00	69,595.70	665.70
- хувийн			-
- хувьцаат			-
Хуримтлагдсан үр дүн	29,016.80	41,714.00	12,697.20
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,286.60	69,109.90	(176.70)
Дүн	167,233.40	180,419.60	13,186.20
<i>Үүнээс төрлөөр</i>			
Төсөвт байгууллага, төсөл сан	149,622.30	162,224.40	12,602.10
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,611.10	18,195.20	584.10
Дүн	167,233.40	180,419.60	13,186.20

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр 374.8 сая төгрөгөөр нэмэгджээ. Үүнд: Засгийн газрын оруулсан капитал данс 81.6 сая төгрөгөөр, дахин үнэлгээний нөөц данс 16.7 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 473.0 сая төгрөгөөр өөрчлөлт орсон байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний данс нь 160.0 сая төгрөгөөр буурч, Засгийн газрын оруулсан капитал данс 747.2 сая төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан үр дүн тайлант оны үр дүн 12224.2 сая төгрөгөөр нэмэгдэж, Засгийн газрын хувь оролцоо оны эцэст 180419.6 сая төгрөг болсон байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны өсөлт нь “Суат” ХХК-нд хөрөнгийн дансанд төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг орлогод авсантай холбоотой 720,1

сая төгрөгөөр нэмэгдсэн, Өлгий сумын хүүхдийн 19-р цэцэрлэг 6.7 сая төгрөгөөр хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэн, Өлгий сумын 10-р сургууль 20.5 сая төгрөгөөр бүтцийн өөрчлөлтөөр хөрөнгө шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт нь Дэлүүн сумын хүүхдийн цэцэрлэг 39.5 сая төгрөгөөр, Өлгий сумын хүүхдийн 3-р цэцэрлэг 30.3 сая төгрөгөөр, Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар 29.3 сая төгрөгөөр, Улаанхус сумын Эрүүл мэндийн төв 27.9 сая төгрөгөөр, Буянт сумын Соёлын төв 15.2 сая төгрөгөөр, Улаанхус сумын ЕБ-ын 2-р сургууль 6.1 сая төгрөгөөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 4.1 сая төгрөгөөр, Өлгий сумын 7-р сургууль 3.7 сая төгрөгөөр, Улаанхус сумын ЗДТГазар 2.0 сая төгрөгөөр, Орон нутгийн олон нийтийн радио телевиз 1.1 сая төгрөгөөр, ГХБХБГазар 0.6 сая төгрөгөөр, Алтай сумын Эрүүл мэндийн төв 0.2 сая төгрөгөөр, нийтдээ 160.0 сая төгрөгөөр акталсан хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой тус тус буурчээ.

Аудитын илрүүлэлт: Аудитаар Засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.10. Орлогын данс

Тайлант онд Төсвийн ерөнхий захирагчийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлогоос 701.2 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 139.6 сая төгрөгийн орлого оруулж, нийтдээ 840.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Орлогын ихэнх хэсгийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, Эргэлтийн эмийн сангийн орлого, Соёлын төвүүдийн өөрийн орлого байна.

Тайлант онд нийт 18512.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 378.8 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн тайлангаар үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зардлын данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын илрүүлэлт:ТШЗ болон ТТЗ-ийн тайлангаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1-р сургууль үдийн цайны зардлын төсвөөс 2.6 сая төгрөгийг холбогдох байгууллагуудын зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулж гүний худаг гаргуулан, тоног төхөөрөмж худалдан авсан.
- Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2-р сургууль гэрэл цахилгаан, бичиг хэрэг, тээвэр шатаахуун, шуудан холбоо, хог хаягдал, томилот, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлуудад 19.3 сая төгрөгийг тооцооны данс дамжуулахгүйгээр зарцуулж шууд зардлаар бүртгэж тайлагнасан. Бусад нийтлэг ажил үйлчилгээ, төлбөрийн хураамжийн төсвөөс 17.2 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр илүү ажиллуулсан 6 орон тооны цалингийн зардалд гүйлгэн зарцуулсан.
- Улаанхус сумын Засаг даргын тамгын газар харилцахын данснаас арилжааны банкинд дахь жижиг мөнгөн сангийн дансаар 15.4 сая төгрөгийг бэлнээр зарцуулж кассын тайлан гаргуулж тооцоо хийж баримтжуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан, мөн сумын төсвийн давсан орлогоос зарцуулсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 24 хөтөлбөрт зориулан 96487.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 90321.1 сая төгрөгийг урсгал зардалд, 6166.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 67832.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 19419.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 6333.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 444.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 2321.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 136.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс төвлөрүүлэг шилжүүлгийг хассан дүнгээр нийтдээ 62844.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 18590.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 5927.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 316.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 436.2 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 63.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс авсан нийт санхүүжилтээс 4987.1 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн 2020 оны оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээр нийтдээ 88446.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, төлөвлөснөөс 8041.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвөөс 19419.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас 18590.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 647.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдож, 180.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 444.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж ажиллахаас 316.8 сая төгрөгийн санхүүжилт авч 128.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 499.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1958.6 сая төгрөгөөр тасарсан нь сумуудын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэх орлого, орон нутгийн зарим төсөвт байгууллага, Байгаль хамгаалах сангуудын үндсэн үйл ажиллагаанаас бүрдүүлэхээр төлөвлөсөн орлого тасарснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 88446.4 сая төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Аймгийн Нэгдсэн төсвийн нийт зарлагын 91.1 хувийг бараа үйлчилгээний зардал, 1.2 хувийг урсгал шилжүүлэг, 6.1 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын 68.9 хувийг цалингийн, 9.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 6.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.7 хувийг хангамжийн зардал, 6.4 хувийг нормативт зардал, 6.9 хувийг бусад зардлууд эзэлж байна.

Хүснэгт №09 Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Байгууллагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орон нутгийн төсвийн суурь зарлага	17546.0	15603.4	-1942.6	17.6%
2	Орон нутгийн хөгжлийн сан	6166.6	5391.5	-775.1	6.1%
3	Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв	72775.1	67451.5	-5323.6	76.3%
	Нийт дүн	96487.7	88446.4	8041.3	100%

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.7. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 67 мэдээлэл оруулахаас 42 мэдээллийг бүрэн оруулсан, бүтэн жилийн мэдээллээс батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 мэдээлэл, сар бүр оруулах мэдээллээс Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 1, 4, 5, 6, 11 дүгээр саруудын 15 мэдээлэл, тухай бүр оруулах мэдээллээс Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, төсөв/гүйцэтгэлийн 1, 2, 6 дугаар саруудын 6 мэдээлэл, нийтдээ 25 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мэдээлэл байршуулаагүй асуудал гараагүй байна.

Аудитын илрүүлэлт:

ТШЗ болон ТТЗ, ОНӨААН-ийн санхүүгийн тайлангаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 байгууллагад 674.9 сая төгрөгийн, Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар Цахилгаан шугам сүлжээний газарт 4533.2 сая төгрөгийн, нийтдээ 5208.1 сая төгрөгийн шилэн данстай холбоотой зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн байна.

Нийт 111 байгууллагаас 696.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар 696.1 сая төгрөгийн 99 зөвлөмж, ОНӨААН-д 1 зөвлөмж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид 11 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид төлбөрийн акт тогтоогдоогүй, 60.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1494.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 заалттай зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 10: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	60.3	1	60.3			100%

Зөвлөмж	2	1494.6	1	1084.6	1	410.0	50%
Нийт	3	1554.9	2	1144.9	1	410.0	

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг дахин хянаж үзэхэд 60.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 174.6 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжсэн байна. Харин төсөвт байгууллагын авлага нийт дүнгээр буурч, өглөг өссөн учраас 1319.7 сая төгрөгийн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 182 төсвийн байгууллага, нэгж, 4 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 200 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 187 байгууллага, нэгж аудитад хамрагдаж, 13 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

“Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор татан буулгасан боловч хаалтын баланс гараагүй байна. Үүнтэй холбоотой аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд тус газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр шууд нэгтгэж ирүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас сумын ИТХ, Соёлын төв, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан зэрэг 57 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 130 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Үүнд:

Нийт 110 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 20 байгууллагын санхүүгийн тайланд “хязгаарлалтай” санал дүгнэлт өгөв. Санхүүгийн тайлангаар “Сөрөг” санал дүгнэлт, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгөөгүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийтдээ 20384.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 9913.2 сая төгрөгийн алдааг залруулж, 88.8 сая төгрөгийн зөрчилд 43 төлбөрийн акт тогтоож, 8572.3 сая төгрөгийн зөрчилд 84 албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 1810.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 141 зөвлөмж өгөв. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал гараагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн асуудал гараагүй байна.

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан, Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд зөрүүтэй нэгтгэсэн зөрчил илрээгүй.

Э-тайланд дараах байгууллагуудын төсвийн төлөвлөгөөг зөрүүтэй оруулсан байна. Үүнд:

Аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар нь өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын хувь оролцоо дансыг үндэслэлгүйгээр 461.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, Үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг 345.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлснийг залруулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдөөгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Сумуудын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 14 ТТЗ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан ба 12 сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, Бугат, Ногооннуур сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 8949.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8779.0 сая төгрөгийн алдааг залруулж, 6.0 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 164.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 15 алдаа зөрчилд 13 зөвлөмж өглөө. Бугат сум, Ногооннуур сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэв.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн 182 байгууллагаас 13 байгууллагад итгэл үзүүлж, 57 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 112 байгууллагад бие даасан дүгнэлт гаргасан.

Үүнээс 94 байгууллагад “зөрчилгүй” санал дүгнэлт, Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль, Өлгий сумын ЕБ-ын 10 дугаар сургууль, Баяннуур сумын ЕБ-ын 3-р сургууль, Дэлүүн сумын ЕБ-ын 2-р сургууль, Дэлүүн сумын ЕБ-ын 3-р сургууль, Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг, Дэлүүн сумын 1-р цэцэрлэг, Ногооннуур сумын Хүүхдийн 1-р цэцэрлэг, Ногооннуур сумын Хүүхдийн 2-р цэцэрлэг, Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг, Улаанхус сумын Согог багийн хүүхдийн цэцэрлэг, Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын Хүүхдийн 20-р цэцэрлэг, Бугат сумын Эрүүл мэндийн төв, Сагсай сумын Эрүүл мэндийн төв, Улаанхус сумын Эрүүл мэндийн төв, Өлгий сумын Засаг даргын тамгын газар, Асрамжийн газар зэрэг нийт 18 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 6224.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1134.3 сая төгрөгийн алдааг залруулж, 5089.7 сая төгрөгийн залруулаагүй зөрчилд 78.5 сая төгрөгийн акт тогтоож, 3706.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1304.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгөгджээ.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 4 аж ахуйн нэгж байгууллагаас 2 байгууллагад бие даасан дүгнэлт гаргасан бөгөөд “Суат” ХХК, Цахилгаан шугам сүлжээний газрын санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. “Хала Өркени” ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн. “Жана Өлке” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 59 дүгээр тогтоолоор татан буугдсан байна.

Аудитаар нийт 5211.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4701.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 506.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 11: Харьяа байгууллагуудаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэсэн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Аудитын нэр	Илрүүлэлт						Запруулсан алдаа	Запруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн	Запруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
		Зөрчил		Алдаа		Бүгд				Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушааланд хариуцлага тооцуулах			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	412	5089.7	58	1,134.3	470	6,224.0	58	1,134.3	412	5089.7	46	78.5	166	3,706.7	200	1,304.5	-	-
2	ОНӨААН	9	5211.5	0	-	9	5,211.5	0	-	9	5211.5	2	4.3	3	4,701.3	4	505.9	-	-
3	ТТЗ	29	170.3	26	8,779.0	55	8,949.3	26	8,779.0	29	170.3	1	6.0	8	164.3	17	-	3	-
	Дүн	450	10,471.5	84	9,913.3	534	20,384.8	84	9,913.3	450	10,471.5	49	88.8	177	8,572.3	221	1,810.4	3	-

3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын өр, авлагын барагдалт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналтын ажил, түүний үр дүнг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна. Энэхүү асуудал нь анхаарал татахуйц чухал асуудал байгаа болно.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих бүтэн жилийн мэдээллээс батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 мэдээлэл, сар бүр оруулах мэдээллээс Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 1, 4, 5, 6, 11 дүгээр саруудын 15 мэдээлэл, тухай бүр оруулах мэдээллээс Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, төсөв/гүйцэтгэлийн 1, 2, 6 дугаар саруудын 6 мэдээлэл, нийтдээ 25 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

1.2. Эрсдэл:

Шилэн дансны хууль бүрэн хэрэгжихгүй байх, төсвийн ил тод байдал хангагдахгүй байх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан боловч хаалтын тооллого тооцоо хийгдээгүй, хаалтын баланс гаргаж тайлагнаагүй, өмч хөрөнгийг хаана хүлээн авч бүртгэсэн нь тодорхойгүй, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр нэгтгэж ирүүлсэн байна.

2.2. Эрсдэл:

Тус газрын хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгө дутагдах, алга болох, өмч хамгаалалтад тавих хяналт сулрах эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж:

“Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын хөрөнгийн тооллого тооцоог хийж, хаалтын баланс гаргах, өмч хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөх арга хэмжээ авч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.04.20	Аудитын нэр:	Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БӨА-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих бүтэн жилийн мэдээллээс батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 мэдээлэл, сар бүр оруулах мэдээллээс Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 1, 4, 5, 6, 11 дүгээр саруудын 15 мэдээлэл, тухай бүр оруулах мэдээллээс Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, төсөв/гүйцэтгэлийн 1, 2, 6 дугаар саруудын 6 мэдээлэл, нийтдээ 25 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	-	Зөвлөмж	Засаг дарга, СТСХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Д.Бауыржан, Х.Ербол, Х.Садырбек

2	<p>Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан боловч хаалтын тооллого тооцоо хийгдээгүй, хаалтын баланс гаргаж тайлагнаагүй, өмч хөрөнгийг хаана хүлээн авч бүртгэсэн нь тодорхойгүй, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үлдэгдлээр нэгтгэж ирүүлсэн байна.</p>	-	Зөвлөмж	Засаг дарга, СТСХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Д.Бауыржан, Х.Ербол, Х.Садырбек
	Дүн	-			



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/06

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/124 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын 13.5, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх” тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Х.Ербол/, Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Р.Хуатхан нарт зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2020 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ХУАНГАН

D:\bichig heregl\2021\tushaal.doc